

Батлав. Монгол хэл бичгийн улсын  
олимпиад зохион байгуулах дэд хорооны  
дарга, доктор *Соронзон* Д. Соронзон



## МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН II ДАВААНЫ

### БАГШ НАРЫН СЭДЭВ

Оноо 50, хугацаа 150 минут

#### Санамж:

1. Даалгавруудыг эх сэдэв дээр биш, тусгай цаасан дээр гүйцэтгэнэ.
2. Ажил тус бүрийн дугаар, дэд дугаарыг тодорхой бичнэ.
3. Зарим даалгаврыг эх сэдвээс нь хуулж бичээд гүйцэтгээрэй.

#### Даалгавар гүйцэтгэхэд ашиглах эх

#### Дуутын хадны бичиг\*

- |   |  |
|---|--|
| I) Дээр Тэнгэр ханы аху хийгээд<br>Дэлхий дэх хан Богдосын аху газар<br>Дээр дорын ялгал болбоос бээр<br>Жаргал, хайрлал хоёрын агаар нэгэн буй.        | V) Хол ойроос хулгай хийгч хүмүүн хийгээд<br>Хотыг эргэн гэтэгч чоно хоёрын<br>Илт бие дүр өөр болбоос<br>Идэхийг хүсэх сэтгэлийн агаар нэгэн буй.               |
| II) Агнистайн агуй дахь Бодисад нар хийгээд<br>Алтан дэлхий дэх бодь сэтгэлтэн хоёрын<br>Аху газар ангид болбоос<br>Асрах нигүүлсэхүйн агаар нэгэн буй. | VI) Онон мөрөнд аху халуут эгч минь хийгээд<br>Орхон Туулд агч өвчит бид хоёр<br>Халх, Онниудын газар хол болбоос бээр<br>Хайрлан саналцахын агаар нэгэн буй за. |
| III) Энд хан Богдосын сайн түшмэл хийгээд<br>Эрүүлэгч Эрлэг хааны их ноёд хоёрын<br>Ёс өнгө өөр болбоос<br>Зөв, бурууг ялгахуйн агаар нэгэн буй.        | VII) Энэ биедээ эс золголцвоос<br>Үүнээс хойт төрөл тутамдаа<br>Эх нь гагц хүүхнээ хайрлах мэт<br>Элдэв үйлээр туслалцах болтугай.                               |
| IV) Олз идэш олон ядагч хүмүүн хийгээд<br>Уул модонд явагч араатан хоёрын<br>Аху бие ангид болбоос<br>Алан идэхийн агаар нэгэн буй.                     |  |

*\*Монголын уран зохиолын дээжис (Найман боть) УБ., 1995  
(Хадны бичээсийн эхийг баримжаалж кирилл бичигт хөрвүүлсэн болно.*

#### Нэгдүгээр ажил. Эх, өгүүлбэрийн задлал (30 оноо)

- 1.1. Энэ шүлгийг хэн, хэзээ зохиож, Дуутын хаданд хэзээ, хэн сийлсэн бэ? (2 оноо)
- 1.2. Энэ шүлгийн үүдэл (төрсөн) санаа, сэдвийг товч тайлбарлана уу. (2 оноо)
- 1.3. Шүлгийн гол санааг тодорхойлно уу. Шүлгийн аль бадагт туссан бэ? (3 оноо)

- 1.4. Эхийн эхлэл, гол хэсэг, төгсгөлийг бадгийн дугаараар тэмдэглээрэй. (3 оноо)
- 1.5. Шүлгийн эхний таван бадгийг уншаад, аль бадаг нь учир зүйн хувьд дундаж үнэлэмж илэрхийлж байна вэ? Яагаад? (2 оноо)
- 1.6. Зохиогч Буддын шашныг шүтэж дээдэлдэг байсныг батлах ямар ямар баримт шүлгийн аль аль бадагт байна вэ? (2 оноо)
- 1.7. Шүлгийн бадаг бүрд (I-V) дүрслэгдэж байгаа хүн төрөлхтний төлөөлөл учир зүйн ямар дараалалтай байна вэ? (2 оноо)
- 1.8. Шүлэгт гарч байгаа “Тэнгэр хан, Богдос, Эрлэг хаан” тус бүр юуны төлөөлөл вэ? (3 оноо)
- 1.9. Шүлгийн I, II бадагт хүмүүнийг тус бүр дэд мөр (шад)-д, III, IV, V бадагт тус тус тэргүүн мөрд тавьсныг Та юу гэж тайлбарлах вэ? (2 оноо)
- 1.10. Шүлгийн бадаг тус бүрийн гутгаар мөрд “ялгал, ангид, өөр, хол” гэсэн үг тус тус хэрэглэснийг Та юу гэж ойлгож байна вэ? (2 оноо)
- 1.11. Энэ шүлэгт дүрслэх ямар ямар ур маяг (тропы) ашигласныг жишээгээр тайлбарлаарай. (2 оноо)
- 1.12. Энэ шүлэгт найруулах ямар ур маяг (фигуры) хэрэглэснийг жишээгээр тайлбарла. (2 оноо)
- 1.13. Дараах өгүүлбэрийг гишүүдээр зурж, бүтцийг тодорхойл. (3 оноо)

... Хол ойроос хулгай хийгч хүмүүн хийгээд  
 Хотыг эргэн гэтэгч чоно хоёрын  
 Илт бие дүр өөр болбоос  
 Идэхийг хүсэх сэтгэлийн агаар нэгэн буй.

#### **Хоёрдугаар ажил. Үг зүй, бүтээврийн задлал (10 оноо)**

- 2.1. Дээрх эхэд орсон “агаар” гэдэг уг ямар гаралтай үг вэ? Энэ эхэд ямар утгаар орсон бэ? /Ойролцоо утгыг нь бич./ (1 оноо)
- 2.2. Дээрх эхэд орсон “Агнистай (Агнисда), Бодисад (Бодисадва) гэсэн хоёр үгийн утгыг тайлбарла. (2 оноо)
- 2.3. Дээрх эхэд орсон “болбоос, золголцвоос” гэсэн хоёр үгэнд орсон “-боос, -воос” нөхцөл тус бүр ямар утга илтгэж байна вэ? (1 оноо)
- 2.4. Дээрх эхэд орсон заахын тийн ялгалын нөхцөлийн тэг хувилбартай ямар ямар үг байна вэ? Олж холбоо үгээр нь бичнэ үү. (2 оноо)
- 2.5. Онон, Орхон, Туул аль нь Халхын, аль нь Онниуд (Оннигууд)-ын нутаг вэ? (2 оноо)
- 2.6. Дээрх эхэд орсон “эрүүлэгч” гэдэг үгийг бүтээврээр задлаад, бүтээвэр тус бүрийг нэрлэ. (2 оноо)

#### **Гуравдугаар ажил. Монгол бичиг (10 оноо)**

Дээрх эхийн V, VI, VII бадгийг монгол бичигт хөрвүүлэн бичээрэй.